



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 07 өдөр

Дугаар 31

Мандалговь

Монгол Улсын цол хүртээх, одон,
медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь :

1. Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга Эрдэнэцэцэг овогтой Чагнаадоржийг Монгол Улсын Төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн хүндэт” медалиар, Сайнцагаан сумын 4 дүгээр багийн ахмад настан Хэнмэдэх овогтой Сожидбумыг Монгол Улсын Төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор шагнуулахаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд уламжилсугай.

2. Шагналын материалыг холбогдох хууль, журам, зааврын дагуу бүрдүүлж, дээд шатны байгууллагад хүргүүлэхийг Засаг дарга (С.Бат-Оргил)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Т.БАТЖАРГАЛ